

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Эрүүл мэндийн газрын Эмийн эргэлтийн сангийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/05/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn

Улаангом хот
2022 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Аудитор: Т.Амармэнд
Утас: 70453721, Цахим хаяг: amarmendt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
3. Аудитын тайлан	8
3.1 Ерөнхий зүйл	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал.....	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	10
3.8 Аудитын гол асуудал.....	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	10
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	11
4. Аудитын илрүүлэлт.....	11
4.1 Залруулсан алдаа	11
4.2 Төлбөрийн акт.....	11
4.3 Албан шаардлага.....	11
5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	12

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС

Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2022. 03. 15 № УВА-2022/05/НА-СТА-ОМА
танай _____-ны № _____-т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Увс аймгийн Эрүүл мэндийн газрын Эмийн эргэлтийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, болон тодруулгуудад аудит хийлээ.

Увс аймгийн Эрүүл мэндийн газрын Эмийн эргэлтийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

АОУС 706.7-д тодорхойлсон санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудлыг гараагүй болно.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад асуудал

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

0200200597

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь (Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.БАТСУУРЬ



2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	795,084,253.98	908,108,920.41
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	144,454,738.20	220,011,476.92
	Банканд байгаа бэлэн мөнгө	144,454,738.20	220,011,476.92
	Төгрөг	144,454,738.20	220,011,476.92
31213	Арилжааны банк дахь харилцах	144,454,738.20	220,011,476.92
33	АВЛАГА	79,445,725.70	114,142,532.26
33401	Дансны авлага /ТӨИГ/	9,118,060.00	-
335	Бусад авлага	70,327,665.70	114,142,532.26
33510	Байгууллагаас авах авлага	65,854,383.47	114,142,532.26
33520	Хувь хүмүүсээс авах авлага	4,473,282.23	-
35	БАРАА МАТЕРИАЛ	571,183,790.08	573,954,911.23
351	Түүхий эд материал	571,183,790.08	573,954,911.23
35130	Эм боох материал	571,183,790.08	573,954,911.23
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДІН	62,555,179.82	45,584,664.82
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	62,555,179.82	45,584,664.82
392	Биет хөрөнгө	56,260,979.82	42,525,664.82
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	150,575,694.82	153,055,694.82
39208	Хуримтлагдсан элэгдэл	(101,045,969.00)	(119,955,748.00)
39214	Бусад үндсэн хөрөнгө	27,672,908.00	32,972,608.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(20,941,654.00)	(23,546,890.00)
393	Биет бус хөрөнгө	6,294,200.00	3,059,000.00
39301	Программ хангамж	25,384,964.00	25,384,964.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(19,090,764.00)	(22,325,964.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДІН III=I+II	857,639,433.80	953,693,585.23
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	73,557,998.00	94,314,738.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	73,557,998.00	94,314,738.00
413	Өглөг	73,557,998.00	94,314,738.00
4136	Бусад өглөг	73,557,998.00	94,314,738.00
41361	Байгууллагад телех өглөг	73,557,998.00	94,314,738.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДІН	784,081,435.80	859,378,847.23
51	Засгийн газрын хувь оролцоо	109,472,931.00	109,472,931.00
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	109,472,931.00	109,472,931.00
512	Хуримтлагдсан үр дүн	674,608,504.80	749,905,916.23
51210	Өмнөх үеийн үр дүн	674,608,504.80	674,608,504.80
51220	Тайлант үеийн үр дүн	-	75,297,411.43
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДІН VI=IV+V	857,639,433.80	953,693,585.23

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Код	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,115,843,531.06	1,900,773,557.07
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,115,843,531.06	1,900,773,557.07
110002	Үйл ажиллагааны орлого	1,115,843,531.06	1,900,773,557.07
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,085,878,150.34	1,825,476,145.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,085,878,150.34	1,825,476,145.64
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,085,878,150.34	1,825,476,145.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,085,878,150.34	1,825,076,145.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		4,607,001.00
210101	Үндсэн цалин		4,069,450.00
210104	Урамшуулал		537,551.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		500,000.00
210202	Тэтгэмжийн даатгал		500,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,704,325.00	3,233,900.76
210301	Гэрэл, цахилгаан	1,241,863.00	1,131,542.76
210302	Түлш, халаалт	462,462.00	2,102,358.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,020,637.00	20,818,280.00
210401	Бичиг хэрэг	1,888,950.00	2,268,650.00
210402	Тээвэр, шатахуун	4,224,010.00	6,585,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,822,000.00	936,250.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	194,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	90,000.00	363,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	2,357,500.00	-
210408	Бараа материал акталсны зардал	3,444,177.00	10,665,080.00
2105	Нормативт зардал	994,299,418.04	1,766,829,848.88
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	994,299,418.04	1,766,829,848.88
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,302,602.67	4,111,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	820,000.00	-
210604	Урсгал засвар	14,482,602.67	4,111,000.00
2107	Томилолт, зочны зардал	159,000.00	-
210702	Дотоод албан томилолт	159,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	124,760.00	225,900.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	124,760.00	225,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	59,267,407.63	24,750,215.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,866,279.63	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	53,401,128.00	24,750,215.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		400,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		400,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	29,965,380.72	75,297,411.43
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	29,965,380.72	75,297,411.43

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Код	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,104,930,199.29	1,903,883,713.87
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,104,930,199.29	1,903,883,713.87
110002	Үйл ажиллагааны орлого	1,104,930,199.29	1,903,883,713.87
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,128,306,112.16	1,820,547,275.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,128,306,112.16	1,820,547,275.15
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,128,306,112.16	1,820,547,275.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,820,147,275.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		4,607,001.00
210101	Үндсэн цалин		4,069,450.00
210104	Урамшуулал		537,551.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		500,000.00
210202	Тэтгэмжийн даатгал		500,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,704,325.00	3,276,072.76
210301	Гэрэл, цахилгаан	1,241,863.00	1,173,714.76
210302	Түлш, халаалт	462,462.00	2,102,358.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,576,460.00	10,153,200.00
210401	Бичиг хэрэг	1,888,950.00	2,268,650.00
210402	Тээвэр, шатахуун	4,224,010.00	6,585,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,822,000.00	936,250.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	194,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,447,500.00	363,000.00
2105	Нормативт зардал	1,094,152,684.86	1,797,274,101.39
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,094,152,684.86	1,797,274,101.39
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,722,602.67	9,618,001.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	240,000.00	-
210604	Урсгал засвар	14,482,602.67	9,618,001.00
2107	Томилолт, зочны зардал	159,000.00	-
210702	Дотоод албан томилолт	159,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	124,760.00	225,900.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	124,760.00	225,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,866,279.63	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,866,279.63	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(23,375,912.87)	83,336,438.72
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	5,818,490.00	7,779,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,818,490.00	7,779,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,818,490.00	7,779,700.00
	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,818,490.00	7,779,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(5,818,490.00)	(7,779,700.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(29,194,402.87)	75,556,738.72
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	173,649,141.07	144,454,738.20
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	144,454,738.20	220,011,476.92

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
				Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	109,472,931.00	644,643,124.08	754,116,055.08
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	109,472,931.00	644,643,124.08	754,116,055.08
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	29,965,380.72	29,965,380.72
C08	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	109,472,931.00	674,608,504.80	784,081,435.80
D01	2021 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	109,472,931.00	674,608,504.80	784,081,435.80
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	109,472,931.00	674,608,504.80	784,081,435.80
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	75,297,411.43	75,297,411.43
D09	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	109,472,931.00	749,905,916.23	853,378,847.23

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймгийн Эрүүл мэндийн газрын Эмийн эргэлтийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Амармэнд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Эрүүл мэндийн газрын Эмийн эргэлтийн сангийн 2021 оны санхүүгийн тайланг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 38 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Увс аймгийн Эрүүл мэндийн газрын Эмийн эргэлтийн сан нь Эрүүл мэндийн сайдын 2011 оны 297 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан “Эмийн эргэлтийн сангийн ажиллах журам”-аар үйл ажиллагаагаа зохион байгуулдаг Увс аймгийн 18 сумын хүн амыг зайлшгүй шаардлагатай эмээр хангах, сум, багийн түвшинд эрүүл мэндийн анхны тусламж, үйлчилгээг тогтвортой, хүртээмжтэй хүргэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагатай гэж үзэж шалгахад дотоод аудитын чиг үүрэг бүхий байгууллагуудаас 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд нь хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд Увс аймгийн Эрүүл мэндийн газрын Эмийн эргэлтийн сангийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,825,476.1 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 9,127.3 мянган төгрөгөөр тооцсон, гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 9,127.3 мянган төгрөгийн 80 хувиар тооцож 7,301.9 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй байна.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Увс аймгийн Эрүүл мэндийн газрын Эмийн эргэлтийн сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 96,054.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	144,454.7	200,011.4	55,556.7
Авлага	79,445.7	114,142.5	34,696.8
Бараа материал	571,183.7	573,954.9	2,771.2
Үндсэн хөрөнгө	62,555.1	45,584.6	-16,970.5
Нийт хөрөнгө	857,639.4	953,693.5	96,054.1
Өр төлбөр	73,557.9	94,314.7	20,756.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	784,081.4	859,378.8	75,297.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	857,639.4	953,693.5	96,054.1

Мөнгөн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 200,011.4 мянган төгрөг болж 55,556.7 мянган төгрөгөөр өссөн нь Ковид-19 цар тахалтайгаар холбоотойгоор ард иргэдийн болон сумдын эмнэлгийн эм боох материал худалдан авснаас шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 114,142.5 мянган төгрөг 34,696.8 мянган төгрөг болж өссөн нь багийн эмч, ард иргэд нарт зээл эм олгосноос шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 573,954.9 мянган төгрөг болж 2,771.2 мянган төгрөгөөр өссөн нь эм боох материалын үлдэгдэл нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 45,584.6 мянган төгрөг болж 16,970.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдлийн зардал нөлөөлсөн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 94,314.7 мянган төгрөг болж 20,756.8 мянган төгрөгөөр өссөн нь Эмийн эргэлтийн сангийн нөөц бүрдүүлснээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 859,378.8 мянган төгрөг болж 75,297.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 784,930.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 739,597.9 мянган төгрөгөөр өссөн нь Ковид 19 цар тахалтай холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал байхгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Увс аймгийн Эрүүл мэндийн газрын Эмийн эргэлтийн сангийн хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 137, хугацаа хоцроож мэдээлсэн 12 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сумдын Эмийн эргэлтийн сангийн урсгал зарцуулалтын зардлыг зардлын зүйл ангиар нь үнэн зөв тусгаж байх, хяналт тавихтай холбоотой асуудлыг цаашид анхаарч ажиллах нь зүйтэй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4,942.1 мянган төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснээс, 42.1 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 4,500.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 400.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 дэх хэсэгт “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасныг зөрчин Зүүнговь сумын эмийн эргэлтийн сан нь авлагыг 42.1 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн байсныг аудитын явцад залруулав.

4.2 Төлбөрийн акт

1. Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт “Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, 39.1.2 дахь заалтад “Албаны эрх мэдлээ хэтрүүлэх”, 39.1.3 дахь заалтад “Хуульд нийцээгүй шийдвэр гаргах”, Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын 1.2-т “Шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх”, Эрүүл мэндийн сайдын 2011 оны 297 дугаар тушаалаар батлагдсан “Эмийн эргэлтийн сангийн ажиллах журам”-ын 3 дахь хэсгийг хэрэгжүүлэн ажиллахгүйгээр Зүүнговь сумын Засаг дарга нь 2021 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн Б/06 дугаар захирамжаар Эрүүл мэндийн төвд Шүдний эмчийг томилж Эмийн эргэлтийн сангаас 4,500.0 мянган төгрөгийн цалинг олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоохоор болов.

4.3 Албан шаардлага

1. Монгол улсын эрүүл мэндийн сайдын 297 дугаар тушаалаар баталсан Эмийн эргэлтийн сангийн ажиллах журмыг хэрэгжүүлэн ажиллахгүйгээр Зүүнговь сумын эмийн эргэлтийн сан нь Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/03, 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн А/06, 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/11 дүгээр тушаалуудаар 400.0 мянган төгрөгийн тусламж олгосон алдаа зөрчилд албан шаардлага өгөхөөр болов.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл


/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Увс аймгийн Эрүүл мэндийн газрын Эмийн эргэлтийн сан	3	4,942.1	1	42.1	1	4,500.0	1	400.0		

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЫ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

/Т.АМАРМЭНД/

2022 оны 03 сарын 15-ны өдөр